

ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН СУРГАЛТЫН ОРЧНЫ БҮРДЭЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Б.Буяндэлгэр¹, Б.Нямсүрэн¹, Б.Лхамцэрэн¹

¹ Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн

Өгүүллийн мэдээлэл

Түүх:

Хүлээн авсан: 2023.06.19

Засаж сайжруулсан: 2023.12.26

Хэвлэхийг зөвшөөрсөн: 2023.12.28

Түлхүүр үг:

суралцахуйн орчин, дээд боловсрол,
хөтөлбөр, шаардлага, багш,
суралцагчид

Холбоо барих зохиогч:

Б.Буяндэлгэр

Email: buyandelger@mnier.mn

Хураангуй

Энэхүү судалгаагаар дотоод, гадаадын баримт бичиг, судалгаанд судлагдсан сургалтын орчны талаарх эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлүүдэд их дээд сургуулиудын сургалтын орчинг хэрхэн томъёолж авч үзсэн, тэдгээрийг олон улсын 28 их дээд сургуулиудын мэдээлэлтэй харьцуулан, ялангуяа багш бэлтгэдэг сургуулийн орчны нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж тавигдах нийтлэг шаардлагыг тодорхойлж, орчныг хэдэн бүрэлдэхүүнд ангилж авч үзэж болохыг тодруулахыг зорилоо. Тус судалгааны хүрээнд их дээд сургуулиудын орчны бүрдэл хэсгүүдийг харьцуулан, ангилж орчны хамааралыг судлаачдын зүгээс нэгтгэж гаргалаа. Мөн дотоод, гадаадын багш бэлтгэдэг олон улсын 28 их дээд сургуулиудын орчны шинжилгээ, дотоодын багш бэлтгэдэг хөтөлбөртэй их сургуулийн орчинд тавигдах нийтлэг шаардлага, магадлан итгэмжлэлийн шалгуур, судалгааны үр дүнгүүд болон боловсролын чанарын тайлан шинжилгээ зэргийг ашиглан авч үзсэн бөгөөд орчин нь материаллаг орчин, цахим орчин, сэтгэл зүйн (үйлийн), нийгмийн хариуцлага, үйлчилгээний орчин гэсэн 4 бүрэлдэхүүнтэй байвал зохистой хэмээн дүгнэж байна.

Article Info

Authors:

Buyandelger, B¹, Nyamsuren, B¹,
Lkhamtsuren, B¹

¹Mongolian National Institute for
Educational Research

Article history:

Received: Jun 19, 2023

Revised: Dec 26, 2023

Accepted: Dec 28, 2023

Keywords:

Higher education, learning
environment, curriculum,
requirements, teachers, students

HIGHER EDUCATION INSTITUTION COMPOSITION OF THE LEARNING ENVIRONMENT

Abstract

In this study, the research team analyzed how the learning environment of universities was formulated in national and foreign documents and studies, and compared them with the information of 28 international universities, especially the conditions of the school environment where teachers are trained. We aim to define the requirements and clarify how many components of the environment can be classified into parts. Within the framework of this study, the researchers have compared and classified the environmental components of universities and combined them by correlation and contextually. Besides, the environment analysis of 28 international universities that train domestic and foreign teachers, the common requirements for the environment of universities with domestic teacher training programs, accreditation criteria, research results and education quality reports were considered. Furthermore, it is concluded that the environment is appropriate if it has 4 components: material environment, digital environment, psychological (practical), social responsibility, and service environment.

УДИРТГАЛ

Мэдлэгт суурилсан эдийн засагт шилжихийн чухал хүчин зүйлийн нэг нь дээд боловсролын оролцоог сайтар хангах явдал юм. Тиймээс дээд боловсролын сургалтын байгууллагууд үйл ажиллагаагаа тогтмол сайжруулж, нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн хөтөлбөр хэрэгжүүлдэг байх нь чухал.

Боловсролын түвшин бүрд хөтөлбөрийг хэд хэдэн янзаар тодорхойлсон байдаг. “Хөтөлбөр гэдэг нь оюутны сурах зорилго, хүрэх үр дүн (ур чадвар, мэдлэг, хандлага); агуулга (суралцсан тухайн чиглэл); дараалал (агуулгын дэс дараалал); суралцагч; сургалтын арга зүй, сургалтын үйл ажиллагаа; сургалтын нөөц (сургалтын материал, сургалтын орчин); үнэлгээ (эдгээр туршлагауудын үр дүн, оюутны суралцах үйл явцыг үнэлэхэд ашиглах аргууд); туршлага, үнэлгээнд тулгуурлан сургах, сурах үйл явцыг сайжруулахаар хийж буй өөрчлөлт зэргийг бүгдийг багтаасан өргөн утгатай” хэмээн тодорхойлжээ (Lattuka, L.R. Stark, J. S., 2009). Тиймээс хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих чухал бүрэлдэхүүн болох суралцахуйн орчинд анхаарал хандуулан ажиллах хэрэгцээ байсаар байна. Энэхүү судалгаагаар дээд боловсролын сургалтын орчны талаар үндэсний болон олон улсын бодлогын баримт бичгүүд, эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлүүд, үндэсний болон гадаадын их, дээд сургуулиудын хөтөлбөрүүдэд хэрхэн томьёолж буйд харьцуулсан шинжилгээ хийв. Харьцуулсан судалгааны үр дүнг бага боловсролын багш бэлтгэх их, дээд сургуулийн хөтөлбөрийн сургалтын орчин, нөөцөд тавих шаардлагыг боловсруулахад ашиглав.

СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ

Үндэсний болон олон улсын боловсролын бодлого, эрх зүйн баримт бичиг, судалгааны бүтээлүүдээс үзэхэд сургалтын орчны асуудлыг цогцоор нь тодорхойлсон байна. Тухайлбал, “Сургуулийн суралцахуйн орчин гэдэг нь сургалтыг дэмжсэн, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж буй анги, сургууль болон сургуулийн олон нийтийг хэлнэ (БСҮХ, Боловсролын чанар түүнд нөлөөлж буй хүчин зүйлийн судалгаа, 2020). Сургалтын үйл явцаас (талуудын хамтын оролцоотой хэлэлцүүлэг, хичээл заах, бие даан болон хамтран ажиллах зэрэг олон талт, тэнцвэртэй нэгж хичээлээс) эхлээд сургуулийн соёл (сургуулийн манлайлал, сэдэлжүүлэлт, багшийн хөгжил) болон олон нийтийн түншлэл (эрүүл мэндийн байгууллага, сурагчдын сэтгэл зүйн асуудлуудад тусламж үзүүлэх бусад байгууллага) зэргийг багтаан ойлгоно (Rehaf, 2019).

Боловсролын чанар, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн судалгаанд дурдсанаар боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журам (хөгжлийн бэрхшээлтэй иргэн, багш, оюутныг нэвтрүүлэх зориулалтын шат, ариун цэврийн өрөө, стандартын шаардлага хангасан биеийн тамирын танхимтай байна), дээд боловсролын сургалтын байгууллагыг аттестатчилах журам, Монгол улсын барилгын дүрэм, ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлтийн дүрэм, сургалт-хүмүүжлийн байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм зэрэг захиргааны актууд нь сургалтын материаллаг болон сэтгэл зүйн, үйлчилгээний орчны зохицуулалтад тодорхой түвшинд чиглэсэн байгааг онцолжээ.

ТХЗ 4.а зорилтыг “2030 он гэхэд бүх нийтийн аюулгүй, хүчирхийлэлгүй, инклюзив оролцоог хангасан, үр өгөөжтэй суралцах орчин бүрдүүлж, боловсролын байгууллагын дэд бүтцийг хүүхдэд ээлтэй, хөгжлийн бэрхшээл болон жендэрийн мэдрэмжтэй болгон шинэчлэн сайжруулах” хэмээн тодорхойлсон билээ (Юнеско, 2015). Сургалтын орчны талаарх олон улсын эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлүүдээс үзэхэд суралцахуйн орчин нь суралцагчийн сурлагын амжилтад 12-25 хувь хүртэл нөлөөлдөг гэжээ (БСҮХ, Боловсролын чанар түүнд нөлөөлж буй хүчин зүйлийн судалгаа, 2020).

“Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого” (2014-2024), “Боловсрол” үндэсний хөтөлбөр (2010-2021), “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө” (2021-2030) зэрэг боловсролын дунд хугацааны бодлогын баримт бичигт “боловсролын байгууллагын орчинд суралцагчийг эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн сөрөг үзэгдлээс хамгаалах нөхцөл, боломжийг бүрдүүлнэ”, “иргэн бүрд насан туршдаа боловсрол эзэмших орчин, нөхцөл, боломжийг бүрдүүлэн, нас, бие, сэтгэцийн онцлог, авьяас, хүсэл, сонирхолд нийцүүлж мэргэжил, чадвараа дээшлүүлэх сургалтын төрөл, хэлбэрийг дэмжин хөгжүүлнэ, сургалтын стандартад нийцүүлэн сургалтын орчныг сайжруулж, шинэ, дэвшилтэт техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах” хэмээн тусгажээ (Монгол Улсын ЗГ, 2021) .

Үндэсний хөгжлийн бодлогын болон дээд боловсролын эрх зүйн баримт бичгүүдэд сургалтын материаллаг орчныг хөгжүүлэх талаар “дээд боловсролын сургалтын байгууллагын дэд бүтцийг сайжруулах” (БСШУСЯ, 2020), суралцагч төвтэй сургалтын үйл ажиллагааг дэмжсэн сургалтын орчинд тавих шаардлагыг боловсруулж, стандартад нийцсэн дэд бүтцийг бий болгох хэрэгтэй хэмээн тэмдэглэжээ (ЦХХХЯ, 2021). Цаашлаад ногоон орчны үнэлгээ, ухаалаг технологитой уялдуулан дээд боловсролын сургалтын орчны стандартыг сайжруулан баталгаажуулах хэрэгцээ байсаар байна. БШУС-ын А/174 дугаартай тушаалаар баталсан “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-ын 2.5.1-д “Сургалтын тусгай зөвшөөрөл болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэх байгууллагын тогтоосон шаардлагад нийцсэн материаллаг болон материаллаг бус орчныг бүрдүүлсэн байна” гэжээ (БМИҮЗ, 2018). Дээд боловсролын сургалтын байгууллагыг магадлан итгэмжлэх шалгуур, шаардлагын шалгуур 5-д ‘сургууль нь эрхэм зорилго, зорилтуудаа үр ашигтай хэрэгжүүлэх материаллаг (анги танхим, тоног төхөөрөмж, лаборатори, номын сан) болон технологийн нөөцийг бүрдүүлэх, байнга шинэчлэх бодлого, зохицуулалттай байна’ гэжээ. Харин үндэсний үнэлгээ, магадлан итгэмжлэх зөвлөл нь (NAAC-National Assessment and Accreditation Council)¹ 2021 оны байдлаар олон улсын 655 их, дээд сургууль, 13316 коллежийг 7 шалгуур, 34 дэд үзүүлэлтээр магадлан итгэлжилсэн байна. Тэдгээр шалгуур үзүүлэлтүүдийн ангиллыг үзэхэд, материаллаг орчинд дараах хүчин зүйлүүд хамаарч байна (хүснэгт 1).

Хүснэгт 1. NAAC -ын дээд боловсролын байгууллагад тавигдах орчны шалгуур үзүүлэлтүүд

Орчны ангилалын 4 бүрэлдэхүүн хэсэг	Шалгуур	Үзүүлэлт
Материаллаг орчин	1. Дэд бүтэц, сургалтын нөөц	1.1 Сургуулийн байр
		1.2 Номын сан суралцахуйн эх үндэс
		1.3 Мэдээллийн технологи (ИТ), технологийн дэд бүтэц
		1.4 Сургуулийн байр, сургуулийн хотхоны зохион байгуулалт, үйлчилгээ
Сэтгэл зүй болон нийгмийн хариуцлага, үйлчилгээний орчин	2. Оюутны дэмжлэг ба ахиц дэвшил	2.1 Оюутныг дэмжих үйлчилгээ
		2.2 Оюутны ахиц дэвшил
		2.3 Оюутны оролцоо, оюутанд чиглэсэн үйл ажиллагаа
		2.4 Төгсөгчдийн оролцоо
	3. Байгууллагын үнэт зүйл, сайн туршлага	3.1 Байгууллагын үнэ цэнэ, нийгмийн хариуцлага

¹БНЭУ-ын Үндэсний үнэлгээ, магадлан итгэмжлэлийн зөвлөл (NAAC) нь дээд боловсролын байгууллагуудыг үнэлж, магадлан итгэмжлэх байгууллага юм.

		3.2 Сайн туршлага
		3.3 Байгууллагын өвөрмөц байдал

Эх сурвалж: NAAC for Quality and Excellence in Higher Education (p.24)

Олон улсын болон үндэсний хэмжээний бодлого, эрх зүйн баримт бичгүүд, эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл, дотоод, гадаадын их, дээд сургуулиудын орчны агуулгын шинжилгээнээс дараах үр дүнг (хүснэгт 2) харж болно.

Хүснэгт 2. Гадаад баримт бичиг, судалгаанд туссан байдал

Орчны бүрэлдэхүүн/ байгууллагын нэр	UNESCO	OECD	Гадаад бусад эх сурвалж/судалгаа
Материаллаг орчин	CO2 түвшнийг хянах болон агааржуулалтын хурд, бусад материаллаг зүйлийг хянах хүчин зүйлүүд (температур, харьцангуй чийгшил, цуурайтах цаг хугацаа, дуу чимээ, гэрэлтүүлэг, тоосжилт, чийгшил, хөгц мөөгөнцөрт өртсөн эсвэл өртөөгүй)	Ундны усны байршил, ариун цэврийн байгууламж, галын аюулгүй байдал. Онцгой байдлын үеийн гэрэлтүүлэг. Сургуулийн аюулгүй тохижилт, тээврийн хэрэгслийн болон явган хүний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан тохижилт, бүтээн байгуулалт	Үдийн цайны өрөө, коридор, шатны хонгил, тоглоомын болон сургуулийн талбай, машин, автобусны зогсоол, барилгын зай багтаамж, орчны угаалгын бодисын хэрэглээ
Цахим орчин	Дижитал бичиг үсгийн боловсрол, дижитал чадварыг хөгжүүлэх, хиймэл оюун ухаанд суурилсан сургалтын орчин	Интернет, дижитал медиа компьютер, сүлжээний техник хангамж, гар утас, таблет, дижитал камер	
Сэтгэл зүйн орчин	Сургуулийн сэтгэц-нийгмийн уур амьсгал, харилцааны чанар, сургалтын үйл явцад ашигласан арга барил, ангийн удирдлага, сахилга бат, сурагч, багш нарын сайн сайхан байдал, нийгэм, сэтгэл санааны байдал	Сайн сайхан байдал: бие бялдар, сэтгэл зүй, танин мэдэхүй, нийгэм, эдийн засгийн сайн сайхан байдал.сэтгэл хөдлөл, сэтгэцийн эрүүл мэнд, хүн хоорондын болон харилцааны ур чадвар	Ангийн менежмент, сахилга бат, сурагчдын сурлага, зан үйлийн эерэг дадал
Нийгмийн хариуцлага, үйлчилгээний орчин	"эмнэлзүйн тусламж хэрэгтэй хүүхдүүдэд үйлчилгээ үзүүлэх		

Үндэсний болон олон улсын хэмжээнд хийсэн судалгаанаас үзэхэд Монгол улс сургалтын орчинг материаллаг, сэтгэл зүйн, үйлчилгээний талаас нь үзэж байна (UNESCO, 2015), (Borgonovi, F., Pál, J., 2016), (OECD, www.oecd.org, 2013), (García-Tudela, P.A. et al, 2021), &. (Rivlin, L.G., & Weinstein, C. S., 2005).

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Дээд боловсролын байгууллагын сургалтын орчны бүрдлийг шинжлэх зорилготой энэ хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- Үндэсний болон олон улсын боловсролын бодлого, эрх зүйн баримт бичигт сургалтын орчны талаар авч үзсэн байдалд шинжилгээ хийх (content analysis),
- Үндэсний болон гадаадын их, дээд сургуулийн сургалтын орчны бүрдэлд шинжилгээ хийх (desktop review).

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгаанд дараах эрх зүй, бодлогын баримт бичиг, судалгааны материалыг ашиглав. Үүнд:

- Хууль, эрх зүйн актууд:* Боловсролын багц хуулиуд, Дээд боловсролын сургалтын хөтөлбөр, байгууллагыг магадлан итгэмжлэх шалгуур, шаардлага, “Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага² (MNS5742:2019), “Дээд боловсролын байгууллагад тавигдах шаардлага, стандарт, үзүүлэлт (БСШУ-ны Сайдын 2007 оны 74 тоот тушаал), “Оюутны дотуур байрны үйлчилгээ. Ерөнхий шаардлага (MNS 5869:2008)”;
- Олон улсын болон үндэсний бодлогын баримт бичгүүд:* “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Боловсролын салбарын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө (2021-2030), School environment, policies, and status (UNESCO, 2015), Innovative Learning Environments (OECD,2013), 28 их сургуулийн албан ёсны цахим хуудас;
- Судалгааны тайлан, сургалтын хөтөлбөр:* Дотоодын болон гадаадын их сургуулийн “Багш, бага боловсрол” сургалтын хөтөлбөр (МУБИС, Дорнод их сургууль, Ховд их сургууль, Auckland их сургууль (Шинэ Зеланд), George Mason их сургууль (АНУ), Dublin City их сургууль (Ирланд), St. Joseph's багшийн коллеж (Ямайка), Hiroshima их сургууль (Япон), Москва хотын багшийн их сургууль (ОХУ)), Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хэрэглэгдэхүүний жишиг жагсаалт (БСҮХ, 2022), Эрдэм шинжилгээний өгүүлэл, тайлан

Баримт бичгийн шинжилгээнд desktop review³ ашигласан бөгөөд дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын орчны бүрдэл хэсэгтэй холбоотой шалгуурыг 4 ангилж болохоор байна. Энэхүү судалгааны ажил нь нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхдээ түлхүүр агуулгыг харьцуулсан бөгөөд тоон шинжилгээний аргыг ашиглаагүй болно.

Хүснэгт 3. Үндэсний болон олон улсын боловсролын бодлогын баримт бичигт туссан байдал

№	Агуулгын хүрээ	Тайлбар
1.	Материаллаг орчин	байгалийн хүчин зүйл (гэрэлтүүлэг, агааржуулалт), сургуулийн барилга байгууламж, түүний өнгө дизайн зэрэг тохижилтын чанар, аюулгүй байдал сургуулийн дэд бүтэц, тохиромжтой буюу тохирсон нөөц, тоног төхөөрөмж гэх мэт;
2.	Цахим орчин	мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилан, тэгш, хүртээмжтэй боловсрол олгох, удирдах, сурган хүмүүжүүлэх ажлыг зохион байгуулахад чиглэсэн өргөн хүрээтэй сургалтын орчны экосистемийн нэг хэсэг;

² <https://estandard.gov.mn/standard/reader/1758#23-lveoflxlgkwiurl.jpg>

³ Desktop review аргыг бага боловсролын багш бэлтгэж буй дотоод, гадаадын их сургуулиудын хөтөлбөрийн талаарх мэдээлэл цуглуулахад ашиглав.

3.	Сэтгэл зүйн орчин	сургалтын орчны уян хатан байдал, аюулгүй тайван, ялгаварлан гадуурхалтгүй орчин, багшийн зан үйл, эерэг байдал, мотиваци, зохион байгуулалт, суралцагч бүрт хамааралтай хүндлэл, дэмжлэг бүхий найрсаг, стрессгүй, хүлээн зөвшөөрсөн, эрүүл, аюулгүй, хамгаалалттай, жендэрийн мэдрэмжтэй орчин гэх мэт;
4.	Нийгмийн хариуцлага, үйлчилгээний орчин	ялгаварлан гадуурхалтгүй суралцагч бүрийг хүлээн зөвшөөрсөн, дэмжсэн үйлчилгээ, сургуулийн дотоод журам, хооллолт, эрүүл мэндийн үйлчилгээ гэх мэт.

Энэхүү шинжилгээ нь гадаад, дотоодын сургалтын байгууллагын орчны бүрдэл хэсгийг харьцуулан ангилж тогтоосноороо ач холбогдолтой юм.


СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Дээрх шинжилгээний үр дүнгээс харахад сургалтын байгууллагын сургалтын орчин дараах дөрвөн бүрдэл хэсэгтэй байна. Үүнд:

- Материаллаг орчин
- Цахим орчин
- Сэтгэл зүйн орчин
- Нийгмийн хариуцлага, үйлчилгээний орчин

Дотоодын, гадаадын 28 их дээд сургуулиудын харьцуулалт, цаашлаад багшийн 10 сургууль, коллежид орчны бүрдэл хэсгийг шинжлэн үзлээ.

Зураг 1.ИДС-уудад орчны бүрдэл хэсэг туссан байдал



1. Материаллаг орчин

Монгол улсын дээд боловсролын сургалтын байгууллагууд “Дээд боловсролын байгууллагад тавигдах шаардлага, стандарт, үзүүлэлт (БСПУ-ны Сайдын 2007 оны 74 тоот тушаал)-ийн биелэлтийг хангахад чиглэж, сургалтын материаллаг орчныг бүрдүүлэн ажилладаг. Дотоодын болон гадаадын 28 их сургуулийн материаллаг орчинд их сургуулийн хотхон (кампус) барилга, байгууламж, их сургуулийн номын сан, хурлын танхим, урлаг, соёлын цогцолбор, спортын цогцолбор, сургалтын танхим, лаборатори, гадна талбай, машин, автобусны зогсоол, оюутны хоолны газар, кафе, оюутны байр болон бусад

үйлчилгээний өрөө тасалгааг хамруулан үздэг. Цаашлаад материаллаг орчны аюулгүй байдалд сургуулийн CO₂, хүчил төрөгчийн түвшнийг хянах болон агааржуулалтын хурд, бусад материаллаг зүйлийг хянах хүчин зүйлүүд (температур, харьцангуй чийгшил, цуурайтах цаг хугацаа, дуу чимээ, гэрэлтүүлэг, тоосжилт, чийгшил, хөгц мөөгөнцөрт өртсөн эсвэл өртөөгүй) сургуульд тамхи татах орон зай, ундны ус, ариун цэврийн байгууламж, галын аюулгүй байдал, онцгой байдлын гэрэлтүүлэг (UNESCO, 2020), аюулгүй байх орчныг дизайнчлах, орон зайн бүтэц нь байрны оршин суугчдын бие махбодын аюулгүй байдлыг хамгаалдаг байх, ариутгалын бодисын зохистой хэрэглээ, барилгын систем, материал, тээврийн хэрэгслийн болон явган хүний хөдөлгөөний аюулгүй байдал зэргийг хамруулан үздэг байна (OECD, www.oecd.org, 2020).

2. Цахим орчин

Их дээд сургуулийн сургалтын цахим орчны бүрдүүлэгч хэсэгт цахим сургалтын систем, сургуулийн удирдлагын мэдээллийн систем, интернэтийн сүлжээ, техник хангамж, дижитал хэрэглэгдэхүүн, боловсролын нээлттэй нөөц материал, лицензтэй программ хангамж болон эдгээрийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр авч үзжээ. Тухайлбал,

- Орон зай, цаг хугацаанаас үл хамааран багшлахуй, суралцахуйг дэмжих *цахим сургалтын систем (LMS)*;
- *Сургуулийн веб сайт*, сургуулийн талаар мэдээлэл түгээх хэрэгсэл;
- *Сургуулийн удирдлагын мэдээллийн системийн* тусламжтайгаар:
 - *Оюутны хувьд*: Цахим картыг ашиглан шалгалтын дүн болон суралцах хугацаандаа судалсан бүх хичээлийн дүн, кредит болон ерөнхий голч дүн, өөрийн хувийн мэдээлэл, төлбөрийн мэдээлэл зэргийг хянах, харах боломжтой.
 - *Хичээл зааж байгаа багш нарын хувьд*: Өөрийн хичээлийн явцын үнэлгээг ums системд оруулах, сурлагын амжилт, чанарын үзүүлэлтийг авах боломжтой.
 - *Зөвлөх багшийн хувьд*: Ангийн оюутнуудын анкет, бусад материал, оюутны судалсан хичээлүүдийн дүн, багц цаг, ерөнхий голч дүн зэрэг мэдээллийг харах боломжтой.
 - *Сургуулийн захиргаа, сургалтын алба, бүртгэл мэдээллийн алба, оюутны хөгжлийн албадын хувьд*: Оюутны мэдээллийг харах, түүнийг ашиглан судалгаа хийх; оюутны дүнгийн болон суралцаж байгаа тухай тодорхойлолтыг гаргах; тухайн улиралд орох хичээлүүдийн хуваарь, заалгаж байгаа багшийг нь мэдэх; төгссөн оюутны диплом болон дипломын хавсралтыг бэлтгэх ба хэвлэх; ерөнхий дүгнэлт хийх, шийдвэр гаргах; хичээл заасан багшийн тухай болон хичээлийн тухай судалгаа оюутнуудаас авах боломжтой.
 - *Санхүүгийн системийн хувьд*: Сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд Daemonol программыг ашигладаг. Тус программаар дамжуулан сургалтын төлбөр төлөлтийг хянах, санхүүгийн орлого зарлагын ангилал, үр дүнгийн мэдээллийг удирдлага авах боломжтой байдаг.
- *Номын сангийн системийн хувьд*: Номын сангийн цогц программыг ашигласнаар оюутан, багш, ажилтан, ажилчид хэрэгцээт номын каталогоос хайлт хийх, уншлагад байгаа эсэхийг үзэх, шинээр нэмэгдсэн ном сэтгүүлийн мэдээллийг авахын зэрэгцээ онлайн номын сангаар үйлчлүүлэх боломжтой.
- *Интернэтийн сүлжээнд* өндөр хурдны шилэн кабелиар холбогдсон байдал, утасгүй интернэтийн сүлжээ;
- *Компьютер, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хувьд* сургалтын зориулалтаар компьютерын лаборатори, дижитал студи, сервер компьютер, сүлжээний техник хэрэгсэл, гар утас, таблет, камер зэрэг хөдөлгөөнт төхөөрөмжүүдийг ашиглаж байна.

- *Дижитал хэрэглэгдэхүүн, боловсролын нээлттэй нөөц материалын хувьд* сургалт, судалгааны зориултаар ашиглах цахим сурах бичиг, ном, гарын авлага, цахим хичээл, аудио, видео контент бүхий суралцагч, багшид зориулсан нэгдсэн сантай байна. Үүнээс гадна, тухайн сургуулиуд Eduteka: <https://eduteka.icesi.edu.co/>, Edu Fi: <https://www.opf.fi/en>, RRU Open Educational Resources: <https://oer.royalroads.ca/moodle/> зэрэг сургалтын нээлттэй нөөц материал (OERs) хэрэглэж байна. EdX (Харвард, Массачусетсийн Технологийн их сургуулийн байгуулсан нээлттэй цахим хичээлийн платформ), Canvas (Багш, оюутан, сургуулиудыг холбосон нээлттэй цахим хичээлийн сүлжээ), Coursera (Станфордын их сургуулийн профессор Андрю Н., Дафне Коллер нарын байгуулсан нээлттэй цахим хичээлийн платформ), Future Learn (Их Британи Нээлттэй их сургуулийн эзэмшдэг Английн 17 их сургуулийн хамтарсан платформ), OpenupEd (Европын Холбооноос дэмжсэн 11 улс орны их дээд сургуулиудыг хамарсан платформ) зэрэг нийтийг хамарсан нээлттэй цахим хичээлийн тэргүүлэх платформуудыг ашиглаж байна. Нээлттэй сурах бичгийн хувьд CK-12 Foundation (Калифорнид оршдог дунд сургуулийн нээлттэй номын сан), OpenStax (Rice их сургуулийн нээлттэй номын сан), California Open-Source Textbook Project (төр хувийн секторын хамтарсан нээлттэй номын сан) зэргийг олон улсын судалгаа, эрдэм шинжилгээний мэдээллийн сангийн тухайд ERIC (АНУ-ын Боловсролын яамны харьяа Боловсролын Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн (IES) цахим номын сан) зэргийг ашиглаж байна.
- *Сургалтад хэрэглэх программ хангамж.* Суралцахад дэмжлэг болох технологи болон программ хангамж нь өргөн болон тусгай хэрэгцээний байхаас гадна, тус сургуулиуд нь программуудаа албан ёсны лицензтэй ашигладаг байна.

Зарим гадаадын их дээд сургуулиудын туршлагаас харахад, тухайлбал, University of Victoria (Канад) сургалт болон суралцагчдад үйлчилгээ үзүүлэх Дижитал сэтгэл зүйн лаборатори (BMED), Дижитал эрүүл мэндийн лаборатори (TIE) зэрэг *тусгай хэрэгцээний лабораториуд* ашиглаж байна.

3. Сэтгэл зүйн (үйлийн) орчин

Сургалтын байгууллагын сэтгэл зүйн орчин гэдэгт багш, суралцагчийн аюулгүй орчинд ажиллах, суралцах боломжийг хангахаас гадна сургалтын орчны уян хатан байдал (сургалтын үйлчилгээг олон хэлбэрээр авах боломж олгосон байх), бусадтай харилцах, дэмжлэг үзүүлэх гэх мэт хүчин зүйлүүдийг илүүтэй анхаарч үздэг байна. Сургуулийн нийгэм-сэтгэлзүйн уур амьсгалд нөлөөлж буй гол хүчин зүйлд суралцагч багш хоорондын харилцаа, сургалтын арга зүй, ангийн зохион байгуулалт болон удирдлага, сахилга бат, суралцагч багш нарын тав тухтай байх орчин, сургууль дээрх хүчирхийлэл, гадуурхалтаас ангид байх, нийгмийн болон сэтгэл санааны байдал зэргийг хамааруулж байна. Түүнчлэн суралцагчийн сурлагын амжилт, суралцахуйд сургуулийн эрүүл ахуй, агааржуулалт, гэрэлтүүлэг илүү нөлөөлдөг бол мэргэжлийн болон дээд боловсролын суралцагчдад эрүүл мэндийн болон сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, хөгжүүлэх үйлчилгээний орчин илүү нөлөөлдгийг цөөнгүй судалгаагаар нотолжээ (Bensabeur. M et al, 2015).

4. Нийгмийн хариуцлага, үйлчилгээний орчин

Их, дээд сургуулиуд суралцагчдад мэдээлэл түгээх, чиглүүлэх, зөвлөх, санал бодлыг хүлээж авах, нийгмийн шаардлагатай үйлчилгээнд хамруулах, дэмжиж урамшуулах, тэтгэлэгт болон солилцооны хөтөлбөрт хамруулах, хүмүүжил, хөгжил, төлөвшлийн болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр оюутны эрэлт, хэрэгцээнд тулгуурласан үйлчилгээг үзүүлж байна. Тухайлбал, оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд:

- Оюутнуудыг хөдөлмөр эрхлэх, дадлага хийх хүсэлтийг хүлээн авах, ажил хийх боломжоор хангах, дэмжлэг үзүүлэх;
- Ажил олгогч байгууллагатай хамтран ажиллах хүний нөөцийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх замаар оюутан, төгсөгчдөө ажлын байраар хангах;
- Оюутныг хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх сургалт зохион байгуулах;
- Сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх;
- Залуу аав, ээжид зөвлөгөө өгөх;
- Хүүхэд асрах үйлчилгээ;
- Оюутнууд болон төгсөгчдөд хөдөлмөр зуучлалын үйлчилгээ (байнгын болон цагийн ажил) явуулах зэрэг үйл ажиллагаа багтдаг байна.

Оюутны чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх, оюутнуудын хөгжил төлөвшлийн чиглэлээр клуб, дугуйлан, оюутны түншлэл, нийгмийн хариуцлагын хүрээнд нийгэмд эерэг өөрчлөлт авчрах сайн дурын ажлууд байна. Мөн их дээд сургуулиудад суралцаж буй гадаад оюутнуудын нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, тэдэнд сурч боловсрох сэдлийг төрүүлэх, зөвхөн өөрийн улс төдийгүй бусад улс орны зан заншил, соёлын ойлголтыг өгөх, танилцуулах, оюутан хоорондын харилцааг өргөжүүлэх зорилготойгоор төрөл бүрийн соёлын үйл ажиллагаа зохион байгуулдаг байна. Түүнээс гадна дотоод, гадаадын их, дээд сургууль нь нийгэмд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний үйл ажиллагаагаар манлайлан оролцох үүрэг хүлээдэг.

ДҮГНЭЛТ

1. Үндэсний болон олон улсын боловсролын бодлого, эрх зүйн баримт бичгийн шинжилгээнээс дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын орчны бүрэлдэхүүнийг материаллаг, цахим, сэтгэл зүйн (үйлийн), нийгмийн хариуцлага, үйлчилгээний гэсэн дөрвөн чиглэлийн хүрээнд цогц байдлаар авч үзэхээр байна.
2. Дээд боловсролын сургалтын байгууллагууд нь ямар ч төрлийн хөтөлбөр хэрэгжүүлэхэд нийтлэг хэрэглэгдэх орчин, нөөц, хэрэглэгдэхүүнийг бүрдүүлэхэд илүүтэй анхаардаг нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.
3. Сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, нөөц нь тухайн сургалтын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай нийтлэг болон тусгай шаардлагыг хангасан байдал нь нэг талаас сургалтын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх, нөгөө талаас оролцогч талуудын (удирдлага, ажилтан, багш, суралцагч, ажил олгогч) сэтгэл ханамжийн түвшнээр илэрхийлэгдэнэ.

НОМ ЗҮЙ

Монгол хэлээр:

- БМИҮЗ. (2018). Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн удирдах зөвлөлийн тогтоол. Улаанбаатар: веб сайт: [mncea.edu.mn.
http://mncea.edu.mn/media/magadlan/content/2019/uajsh2019.pdf](http://mncea.edu.mn/media/magadlan/content/2019/uajsh2019.pdf)
- БСҮХ. (2020). *Боловсролын чанар түүнд нөлөөлж буй хүчин зүйлийн судалгаа*. Улаанбаатар: БСҮХ.
- БСҮХ. (2020). *Боловсролын чанар түүнд нөлөөлж буй хүчин зүйлийн судалгаа*. Улаанбаатар: БСҮХ.
- БСШУСЯ. (2020). Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030. Улаанбаатар: веб сайт: www.meds.gov.mn
- УИХ. (2015). Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024). Улаанбаатар: веб сайт: www.legalinfo.mn

ЦХХХЯ. (2021). Дунд хугацааны стратеги 2022-2025. Улаанбаатар: веб сайт: [crc.gov.mn
https://www.crc.gov.mn/storage/CRC%20Strategy_2025.pdf](https://www.crc.gov.mn/storage/CRC%20Strategy_2025.pdf)

Юнеско. (2021). Монгол улсын боловсролын салбар дахь МХХТ-ийн бодлогын тойм шинжилгээ. Улаанбаатар: веб сайт: <https://unesco.mn/mn/wp-content/uploads/2022/05/ICT-in-Education-Policy-Review-Report-mongolian-1013-1.pdf>

Гадаад хэлээр:

Bensabeur, M et al. (2015). The School Environment and its Relation with the Quality of Teaching Physical Education. *European Journal of Physical Education and Sport*, 130-136.

Borgonovi, F., Pál, J. (2016). A Framework for the Analysis of Student . *OECD Education Working Papers, No. 140. Paris: OECD Publishing*, 36-58.

García-Tudela, P.A. et al. (2021). Smart learning environments: a basic research towards the definition of a practical model. *Smart Learn. Environ*, 9-15.

Lattuka, L.R. Stark, J. S. (2009). Shaping the college curriculum: Academic plans in Context. *International Studies In Educational Administration*, 6-15.

OECD. (2013). The Learning Environment: Reflections on the Function of Facilities. web site: https://www.oecd-ilibrary.org/education/the-learning-environment_767526546174

OECD. (2020) Innovative Learning Environments. web site: [www.oecd.org
https://www.oecd.org/education/ceri/innovativelearningenvironments.htm](https://www.oecd.org/education/ceri/innovativelearningenvironments.htm)

Rehaf, A. M. (2019). Analysis of Educational Quality, a Goal of Education for All Policy. *Higher Education Studies, Canadian Center of Science and Education*, 100-109.

Rivlin, L.G., & Weinstein, C. S. (2005). Educational issues, school settings, and environment . *Elsevier*, 347-364.

UNESCO. (2015). The psychosocial school environment. web site: [unesco.org.com
https://learningportal.iiep.unesco.org/en/issue-briefs/improve-learning/the-psychosocial-school-environment](https://learningportal.iiep.unesco.org/en/issue-briefs/improve-learning/the-psychosocial-school-environment).

UNESCO. (2020). Safe learning environments: Preventing and addressing violence in and around

“Боловсролын Судалгааны Монголын Сэтгүүл”-ийн товч танилцуулга

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн нь 1969-өөс 2021 оныг хүртэлх хугацаанд эрхлэн гаргаж байсан “Эрдэм шинжилгээний бичиг”-ээ 2022 оноос эхлэн шинэ өнгө төрх бүхий “Боловсролын Судалгааны Монголын Сэтгүүл” нэртэйгээр гаргах болсон билээ.

Тус сэтгүүлийг ISSN болон DOI индекстэй хэвлэн нийтэлж байна.

Сэтгүүлийн нийтлэлийн бодлогын хүрээнд дараах зорилтуудыг тавин ажиллаж байна.


- Монгол хэлээр бичсэн боловсролын судалгааны өгүүллийг чанарын шинэ түвшинд хүргэх
- Монголын боловсролд тулгамдаж буй боловсролын асуудлыг хэлэлцэх, нээлттэй форум зохион байгуулах
- Боловсролын судалгаа хийж буй судлаачдын бүтээлийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх, залуу судлаачдыг туршлагажуулах

Боловсролын Судалгааны Монголын Сэтгүүл нь нь хагас жил тутамд хэвлэгдэн гарах ба дараах чиглэлийн дагуу судалгааны өгүүллийг тогтмол хүлээн авна.

- Боловсролын зорилго, философи, онол
- Суралцагчийн хөгжил
- Боловсрол, сургалтын хөтөлбөр судлал
- Боловсролын хүний нөөц
- Мониторинг, үнэлгээ
- Боловсролын удирдлага, зохион байгуулалт
- Боловсролын орчин
- Боловсролын эдийн засаг
- Бусад

Өгүүллийг journal.mnier.mn веб сайтаар өгсөн загварын дагуу бэлтгэн илгээх бөгөөд хянан магадлах үйл ажиллагаа хийж, хэвлэлд шилжүүлэхээр болсон тохиолдолд онлайн хэлбэрээр БСҮХ-ийн албан ёсны веб дээр тавина. Хэвлэн нийтлэхээр зөвшөөрсөн өгүүллүүдийг нэгтгэн жил бүрийн 6 ба 12 дугаар сард хэвлэмэл хэлбэрээр олон нийтэд түгээнэ.

Зохиогчийн өгүүллийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хянан магадлагааг хийж хариу өгнө. Сэтгүүлийн редакцын өгүүлэл хэвлэх үйл ажиллагааны зураглалыг доор үзүүлэв.



Боловсролын чиглэлээр судалгааны ажил хийж буй Таны өгүүллийг нийтийн хүртээл болгох, түгээн дэлгэрүүлэхэд манай сэтгүүлийн хамт олон ямагт баяртай байх болно.

**Таны эрдэм судлалын ажилд өндөр амжилтыг хүсэн ерөөе.
СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ**